

Аргачлалын тайлбар :

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СЭЗТС-ийн хэлтэс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсөвт(аймгийн) төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа.

Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2006 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 194 нэр төрөл болгож 2005 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаар нь ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)- ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог тухайн үед амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн

тоог жилийн дундаж 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.(I, II, III, IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав. 1

2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

Д - дахин

3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор оны эхний 2 сард аймгийн төсөвт 614.9 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 112.6 хувиар биелүүлжээ.

Улсын төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 630.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 582.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 47.6 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар тасалсан байна.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 520.1 сая төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 403.8 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 77.6 хувиар биелүүлж 116.3 сая төгрөгөөр тасаллаа. Аймгийн төсөвт 178.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 162.5 хувиар биелүүлж 68.7 сая төгрөгөөр давуулсан байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн нийт төсвийн орлого 13.1 хувиар буюу 67.5 сая төгрөгөөр илүү, үүнээс аймагт төвлөрүүлсэн орлого 17.1 хувиар буюу 36.8 сая төгрөгөөр бага, харин улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлого 34.8 хувиар буюу 104.3 сая төгрөгөөр илүү байна.

2010 оны эхний 2 сард улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын орлогын төлөвлөгөө 10.6 хувиар, онцгой албан татварын төлөвлөгөө 39.4 хувиар тус тус


тасарч нэмэгдсэн өртгийн албан татварын төлөвлөгөө 31.0 хувиар давж биелэгдлээ.

Оны эхний 2 сард аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөнөөс хувиараа аж ахуй эрхлэгч иргэний орлогын төлөвлөгөө 58.6, орлого тодорхойлох боломжгүй иргэний орлогын төлөвлөгөө 40.7, авто өөрөө явагч хэрэгслэлийн татвар 93.5, бууны татвар 81.7, газрын төлбөр 72.7, улсын тэмдэгтийн хураамжийн төлөвлөгөө 15, хайгуулын болон ашиглалтын лицензийн төлбөр 53.6, ашигт малтмалын нөөцийн төлбөр 32 хувиар тус тус тасарсан бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс хувиараа аж ахуй эрхлэгч иргэний орлого 39.0, өмчийн татвар 45.2, газрын төлбөр 46.0 хувиар, хайгуулын болон ашиглалтын лицензийн төлбөр 23.9, ашигт малтмалын нөөцийн төлбөр 58.5, татварын бус орлого 35.3 хувиар тус тус бага байна.

зориулалтын орлогын албан татвараар, 0.2 хувийг өмчийн албан татвараар, 2.6 хувийг бусад албан татвараар, 1.1 хувийг татварын бус орлогоор тус тус бүрдүүлсэн байна.




Төсвийн орлогын өсөлт, бууралт, онуудаар



Аймгийн төсвийн орлогын 70.9 хувийг тусламжийн орлогоор, 25.2 хувийг орлогын албан татвараар, 0.1 хувийг тусгай

Төсвийн зарлагад орлогын эзлэх хувь, хувиар



2005 оны 2 дугаар сарыг суурь болгон авч жил бүрийн 2 дугаар сарын эцэстэй харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн төсвийн орлого сүүлийн 2 жилд 2005 оны мөн үеэс 5.1 – 5.8 дахин өсч, энэ хугацаанд төсвийн зарлага 3.2 – 3.3 дахин өссөн байна.

Төсвийн орлого, зарлагын өсөлт, 2005 I-II = 100 %

	2005 I-II	2006 I-II	2007 I-II	2008 I-II	2009 I-II	2010 I-II
Орлого	100.0	114.5	223.3	247.8	514.0	581.3
Зарлага	100.0	113.8	181.8	284.0	318.1	327.2

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 4.0 тэрбум төгрөгийг урсгал зардалд зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 2.9 хувиар илүү байна.


Нийт зарлагын 60.7 хувийг цалин хөлсөнд, 6.0 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 26.7 хувийг бусад зардалд, 5.8 хувийг урсгал шилжүүлэгт, 0.8 хувийг хөрөнгө оруулалтанд зориулан зарцууллаа.

Өнгөрсөн оны мөн үеэс цалингийн зардлын эзлэх хувь 1.0 пунктээр, НДШ-ийн зардлын эзлэх


хувь 0.2, бусад зардлын эзлэх хувь 1.0 пунктээр буурч, урсгал шилжүүлэг болон хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь 2.3 пунктээр өссөн байна.

Төсвийн зардлын 21.2 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 53.7 хувийг боловсрол, 19.7 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.9 хувийг нийгмийн даатгал, халамжийн үйл ажиллагаанд, 0.5 хувийг ХАА-н салбарт, 2.0 хувийг ус цаг уур, байгаль орчны үйл ажиллагаанд зориулан зарцууллаа.

2010 оны эхний 2 сар, хувиар



2009 оны эхний 2 сар, хувиар




Ноднингийн мөн үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний салбарт зориулсан зардын эзлэх

хувь 3.0 пунктээр өсч, эрүүл мэндийн салбарынх 0.1 пунктээр, боловсролын салбарынх 4.1 пунктээр тус тус буурсан байна.

Төсөвт 178 байгууллагуудад 4.4 мянган хүн ажиллаж, ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.8 хувиар өссөн байна.

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА



2010 оны 2 дугаар сарын эцэст байгаа өглөг, авлагын хэмжээг сүүлийн 4 жилийн дундажтай харьцуулахад өглөг 9.6 дахин буюу 161.8 сая төгрөгөөр, **авлага 3.4 дахин буюу 63.6 сая төгрөгөөр өссөн байна**

МӨНГӨ, ЗЭЭЛ

Монгол банкны мэдээгээр 2.9 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 16.8 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 17.1 тэрбум төгрөгийг буюу 101.8 хувийг эргүүлэн татсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 872.0 сая төгрөгөөр буюу 41.9 хувиар, гүйлгээнээс татсан мөнгө 1.6 тэрбум төгрөгөөр буюу 10.1 хувиар, гүйлгээнд гаргасан мөнгө 2.4 тэрбум төгрөгөөр буюу 16.4 хувиар тус тус өссөн байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 25.9 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1.4 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 1.6 тэрбум төгрөгөөр буюу 6.0 хувиар буурч, хугацаа хэтэрсэн зээл 405.8 сая төгрөгөөр буюу 41.9 хувиар өсчээ.

1,0 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.0 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 334.2 сая төгрөгөөр буюу 47.4 хувиар өссөн байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 14.1 тэрбум төгрөг болж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 16.3 хувиар буюу 2.0 тэрбум төгрөгөөр өсч, харин оны эцсээс 8.7 хувиар буюу 1.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийт зээлийн 5.3 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байгаа бөгөөд Төрийн банкны нийт зээлийн 8.5, Шуудан банкны 8.0, ХААН банк 5.3, Хас банкны 2.3, Хадгаламж банкны 25.0 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.



Хэрэглээний үнийн индекс

2010 оны 2-р сард судлагдаж буй 194 өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өмнөх оны мөн үеэс 9.1, оны эхнээс 5.9, суурь буюу 2005 оны 12 сараас 79.0, өмнөх сараас 3.7 хувь өсчээ.

Өмнөх сараас хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 9.2, үүнээс хүнсний барааны бүлгийн үнэ 9.6 хувь, үүний дотор мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 22.7, сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 16.2, жимс, талх гурил будааны дэд бүлгийн үнэ 12.3, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 21.4, хувцас бөс барааны дэд бүлгийн үнэ 0.2 хувь тус тус өсч, тээврийн бүлгийн үнэ 2.4 хувиар буурч бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.

Аймгийн ерөнхий индекс, 2-р сард, хувиар

	2010.02/2005.12	2010.02/2009.02	2010.02/2009.12	2010.02/2010.01
ЕРӨНХИЙ ИНДЕКС	179.0	109.1	105.9	103.7



Улсын индексгүй харьцуулсан байдал, 2-р сард

	2010.02/2005.12	2010.02/2009.02	2010.02/2009.12	2010.02/2010.01
Улсын индекс	8.3	5.4	3.0	
аймгийн индекс	79.0	9.1	5.9	3.7




Гол нэрийн барааны өсөлтийн хувь

	ӨОМҮГ-с	өмнөх сараас
цагаан будаа	27	0
хонины мах	0	25
хиам	6	-11
сүү	33	18
үзэм	25	0
төмс	20	20
сонгино	67	33
элсэн чихэр	64	6



Сүүлийн 4 жилийн 2 саруудыг өмнөх сартай харьцуулсан индекс



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :

Хүнсний бараа, ундаа ус 9.4 %
 Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ 9.4 хувь өссөн нь сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 29.4 %, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 20.7 %, сахарын дэд бүлгийн 24.1 хувь, хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 17.1, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 7.6 хувь өссөнтэй холбоотой байна.

Согтууруулах ундаа, тамхи 3.1 %
 Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 % өссөн нь согтууруулах ундааны дэд бүлгийн үнэ 0.4, тамхины бүлгийн үнэ 10.3 % өссөнтэй холбоотой байна.

Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 17.7 хувь өссөн нь хөвөн бөс барааны бүлгийн үнэ 17.9, бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 16.6 % үүнээс эрэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 16.9 % эмэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 9.2 %, хүүхдийн бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 24.6жижиг эдлэл хэрэгслийн дэд бүлгийн үнэ 30.2, гутлын дэд бүлгийн үнэ 17.4 хувь өссөнтэй холбоотой байна.

Орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувь өссөн нь орон сууцны засвар үйлчилгээний дэд бүлгийн үнэ 6.0, усан хангамжийн дэд бүлгийн үнэ 3.3, цахилгаан болон хийн түлшний дэд бүлгийн үнэ 4.6 хувь өссөнтэй холбоотой байна.

Гэр ахуйн бараа, тавилга 10.3 %
 Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 10.3 хувь өссөн нь гэрийн тавилганы бүлгийн үнэ 14.8 %, цахилгаан барааны бүлгийн үнэ 17.3 %, гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы барааны бүлгийн үнэ 28.0 %, оёмол, нэхмэл эдлэлийн үнэ 3.0 % өссөнтэй холбоотой байна.

Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.1 % буурсан нь эм тарианы дэд бүлгийн үнэ 4.6 % буурсантай холбоотой байна.

Тээвэр -1.9 %
 Тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 1.9 % буурсан нь хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний дэд бүлгийн үнэ 2.0 %, тээврийн үйлчилгээний дэд бүлгийн үнэ 4.2 хувь буурсантай холбоотой байна.

Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 7.3 % өссөн нь дуу дүрс гэрэл зургийн мэдээллийн хэрэгслийн дэд бүлгийн үнэ 18.7 %, чөлөөт цаг соёлын үйлчилгээний дэд бүлгийн үнэ 1.5 % өссөнтэй холбоотой байна.

Боловсролын үйлчилгээ 20.7 %
 Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 20.7 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 20.7 хувиар өссөнтэй холбоотой байна.

3Б нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 7.4 %
 Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 7.4 % өссөн нь нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 9.1 хувь өссөнтэй холбоотой байна.

Бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 % өссөн нь хувь хандсан үйлчилгээ 8.2 % өссөнтэй холбоотой байна.


Ажилгүйдэл

Хөдөлмөр зохицуулах албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй эрж буй 2216 ажилгүйдүүд байгаагийн 49.5 хувь нь буюу 1098 эмэгтэйчүүд байна.

Насанд хүрсэн 10.0 мян хүнд 457 ажилгүйдүүд ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 32.1 хувиар өссөн байна.

Оны эхний 2 сарын байдлаар ажилгүйдүүдийн тоо сүүлийн 4 жилийн дунджаас 32.7 хувиар өссөн байна.


Ажилгүйдүүдийн тоо сүүлийн 5 жилээр




Энэ 2-р сард 32 хүн ажилгүйдүүдэд нэмж бүртгэгдэн ажилгүй байсан хүмүүсээс 81 хүн ажлын байнгын болон түр байраар хангагджээ.

2-р сард ажилгүйдүүдэд бүртгүүлэгчдийн 6.3 хувь нь орон тооны цомхтголоос, 9.4 хувь нь сургууль төгссөн, 84.3 хувь нь бусад шалтгаанаар бүртгүүлсэн, ажилд орогчидын 8.6 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 91.4 хувь нь бусад газарт ажилд орсон байна.

XXYX-т шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон хүний тоо, жил бүрийн эхний 2 сараар



Ажилгүйдүүдийн 0.1 хувь нь анх удаа ажил эрж байгаа бөгөөд 52.2 хувь 16-34 насны залуучууд, 17.8 хувь нь дээд, 8.4 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 70.7 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 3.1 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.




Том малын зүй бус хорогдол


Оны эхний малын 6.0 хувь буюу 138.2 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оноос 3.4 дахин буюу 97.9 мянган толгойгоор илүү байна.

Нийт хорогдлын 2.5 хувийг өвчний хорогдол эзэлж байна. 25393 хээлтэгч мал хорогдсон нь том малын зүй бус хорогдлын 18.4 хувийг эзэлж байна.

Нийт хорогдлын 42.0 хувийг хонь, 52.0 хувийг ямаа, 4.0 хувийг үхэр, 2.0 хувийг адууны хорогдол эзэлж байна.



Баруунтуруун, Наранбулаг, Сагил, Өмнөговь, Тариалан, Завхан, Зүүнговь, Түргэн, Зүүнхангай сумдын оны эхний малын 6.6 – 13.3 хувь нь хорогдож аймгийн дунджаас 0.6 – 7.3 пунктээр их, бусад сумдын оны эхний малын 0.6 – 5.2 хувь хорогдсон нь аймгийн дунджаас 0.8 – 5.4 пунктээр бага байна. Ялангуяа Өмнөговь, Тариалан, Завхан, Зүүнговь, Түргэн, Зүүнхангай сумдын оны эхний малын 9.3 – 13.3 хувь нь хорогдоод байгаа нь аймгийн дунджаас ихээхэн дээгүүр байна.



Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ

2009 оны 9 дүгээр сараас эхлэн хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн болох 119 нэрийн бүтээгдэхүүний үнийг бүх сумдаас цуглуулан авч аймгийн дундаж үнэ тооцож байна. Бүтээгдэхүүний нэр,

төрлийг нилээд задалж ангилсан учир өнгөрсөн жилүүдтэй харьцуулах боломжгүй тул өмнөх сартай харьцуулж танилцууллаа.

Малын үнэ 2010 оны 2-р сарын 28-ны байдлаар аймагт тэмээ зарагдаагүй, харин өсвөр болон нас гүйцсэн адуу 161.2 – 287.1 мянга, өсвөр насны болон нас гүйцсэн үхэр, бух 162.5 – 320.0 мянга, өсвөр насны төлөг, нас гүйцсэн эр ба эм хонь, хуц 20.3 – 47.3 мянга, өсвөр насны борлон, нас гүйцсэн эр ба эм ямаа, ухна 14.3 – 32.0 мянган төгрөгний дундаж үнэтэй байна.

Аймгийн дунджаас Тариалан, Сагил, Давст суманд нас гүйцсэн морь, шар, эм үхрийн үнэ 13.0 – 80.0 мянган төгрөгөөр, Тэс, Сагил, Давст, Түргэн, Улаангом суманд нас гүйцсэн эр хонины үнэ 3.0 – 13.0 мянган төгрөгөөр, Түргэн, Зүүнхангай, Цагаанхайрхан, Улаангом суманд нас гүйцсэн эр ямааны үнэ 3.0 – 13.0 мянган төгрөгөөр тус тус илүү ханштай байна.

2 дугаар сарын 28 - ны байдлаар бүх насны адуу, эр ба эм үхэр, эр хонины үнэ өмнөх сартай харьцуулахад 1.7 – 39.6 мянган төгрөгөөр өсч, эм хонь болон бүх насны ямааны үнэ 0.4 – 5.7 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

ХАА - н зарим бүтээгдэхүүн:

Гол нэрийн бүтээгдэхүүн болох ноолуур 32000 , адууны шир 16000 , үхрийн шир 7000 , хонины арьс 1500, ямааны арьс 12000 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Мал, амьтны гаралтай зарим түүхий эдийн үнийг өмнөх сартай харьцуулахад үнээний сүү, хонины мах, адуу ба үхрийн шир, ямааны арьс, ноолуурын үнэ 250 – 3000 төгрөгөөр тус тус өсчээ.


Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн :

Улаан буудай 500.0 мянга, задгай өвс 58.5 мянга, боодолтой өвс 4705, түлээний мод 23750, чацаргана 3750,

сонгино 2000 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад улаан буудай 41.7 мянган төгрөг, боодолтой өвс, сонгино 500 төгрөг, түлээний мод 1370 төгрөгөөр тус тус өсч, харин чацаргана 250 төгрөгөөр буурчээ.






Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 772.2 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.0 хувиар буюу 50.3 сая төгрөгөөр өслөө.



Нийт үйлдвэрлэлтийн 52.5 хувийг хүнс ундааны үйлдвэрлэл, 28.7 хувийг эрчим хүч түгээлт, 10.1 хувийг нүүрс олборлолт, 6.8 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл, 1.2 хувийг усан хангамж, 0.8 хувийг хувцас үйлдвэрлэл эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтэц хувиар, 2010 оны 02 сар



Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор/ нүүрс олборлолт 46.5, хувцас үйлдвэрлэл 43.2, эрчим хүч түгээлт 16.0 хувиар, гурил, гурилан бүтээгдхүүн үйлдвэрлэл 25.5 хувиар, мах үйлдвэрлэл 3.7 дахин тус тус өсч, архи, ундааны үйлдвэрлэл 9.5, усан хангамж 10.1, бусад боловсруулах үйлдвэрлэл /өлөн, шевро, булигар, хөх шир / 15.8 хувиар тус тус буурсан байна.

Оны үнээр 1.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 885.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс борлуулалтын орлого 27.3 хувиар буурсан байна. Нийт борлуулалтын 9.0 хувь буюу 80.0 сая төгрөгийн боловсруулсан өлөн гэдэс болон нүүрс гадаадад экспортолсон байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх эрчим хүч түгээлт 3.5, нүүрс олборлолт 3.1, хувцас үйлдвэрлэл 0.1, пунктээр өсч, хүнс ундааны үйлдвэрлэлтийн хувь 7.6, бусад боловсруулах үйлдвэрлэл 0.1, усан хангамж 0.5 пунктээр буурч, усан хангамж өнгөрсөн оны түвшинд байна.


Салбарын бүтэц

	2008 I-II	2009 I-II	2010 I-II
Цахилгаан дулаан түгээлт	48.3	24.2	28.7
Нүүрс олборлолт	16.1	7.0	10.1
Бусад ашигт малтмал олборлолт	0	0	0
Хүнс ундаа үйлдвэрлэл	32.4	60.1	52.5
Хувцас үйлдвэрлэл	0.7	0.7	0.8
Мод модон бүт үйлдвэрлэл	0	0	0
Бусад боловсруулах аж үйлдвэр	0.7	6.9	6.8
Усан хангамж	1.9	1.2	1.2
Дүн	100.0	100.0	100.0


2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсоноор суурь он буюу 2005 оноос боловсруулах үйлдвэрлэл 8.1, уул уурхай олборлолтын салбар 4.0, эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 2.3 дахин өссөн байна.



Аж үйлдвэрийн салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2005 оны мөн үетэй харьцуулбал өлөн 12.0, архи 8.8 ундаа 5.3, нарийн боов 3.1, нүүрс 4.0, дулаан 2.6 хувиар, түгээсэн цэвэр ус 2.1 дахин өсчээ.



2005 оноос импортын цахилгаан 11.0, цахилгааны хэрэглээ 7.9 хувиар өссөн байна.



Эрүүл мэнд



Энэ оны эхний 2 сард 319 эхээс 321 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 86-аар буюу 21.1 хувиар бага байна.

Гэрийн төрөлт 12 гарсан нь өнгөрсөн оноос 10 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Хүн амын нас баралт 100 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 35 хувь буюу 20 тохиолдлоор нэмэгдэж 1000 хүнээс 1 нь нас барсан байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 22 гарсан нь 1000 амьд төрөлтөнд 68 ноогдож, өнгөрсөн оны мөн үеэс 9 гаралтаар буюу 69.2 хувиар нэмэгджээ.

		2006	2007	2008	2009	2010
Нүүрс	тн	6.7	5.2	7.8	8.6	12.6
Архи	мян л	58.3	112.4	38.4	93.8	82.5
Ундаа	мян л	6.3	5.2	3	7.5	15
Нарийн боов	тн	12	64	45.6	40.8	54.6
Өлөн	мян гог	20	6.2	25.2	37.6	30.1



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Ховд, Тариалан, Түргэн, Сагил, Зүүнхангай, Завхан, Бөхмөрөн сумдад гараагүй, Улаангом суманд аймгийн дунджаас бага бусад сумдад аймгийн дунджаас өндөр байна.


0-1 насны хүүхдийн эндэгдэл 15 гарч нялхсын эндэгдлийн түвшин 47 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4 гаралтаар буюу 20 промилээр нэмэгджээ.



Нийт нас баралтын 22.0 хувийг эмнэлэгийн нас баралт, үүний 22.7 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

2 эх эндэж, 100.0 мянган амьд төрөлтөнд 623 эхийн эндэгдэл ноогдож өнгөрсөн оны мөн үеэс эхийн эндэгдэл 2 дахин нэмэгдсэн байна. Осол гэмтлийн улмаас 12, хорт хавдрын улмаас 29 хүн нас баржээ.






Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 108 болж өнгөрсөн оны мөн үеэс 62.0 хувиар буюу 176 гаралтаар буурсан байна.

10000 хүн тутмаас 14 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд энэ үзүүлэлт Улаангом / 29.1 /, Өмнөговь / 21.3 /, Тэс / 14.6 / сумдад аймгийн дунджаас дээгүүр Баруунтуруун, Завхан, Зүүнхангай, Өлгий, Өндөрхангай, хяргас сумдад гараагүй бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна.


Халдварт өвчний гаралт, сүүлийн 5 жилээр





Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 20.4 хувь нь гепатит, 38.9 хувь нь БЗХӨ, 8.3 хувь нь сүрьеэгээр, 4.6 хувь нь мөөгөнцрөөр, 8.3 хувь нь гахайн хавдраар, 19.5 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.



Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд 2009 - 2 сар



Өнгөрсөн оны мөн үеэс гепатит 36, хамуу 25, бруцеллөз 4, трихоманиаз 1, тэмбүү 6, салхинцэцэг 125 гаралтаар буурч, хүйтэн 17, гахайн хавдар 9, мөөгөнцөр 5 гаралтаар тус тус нэмэгджээ.



Амбулаториор 52.9 мянган хүнд үзлэг хийгдэж, стационариар 3.4 мянган хүн эмчлэгдсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үзүүлсэн хүний тоо 10.5 хувиар бага, хэвтэн


эмчлүүлсэн хүний тоо 5.5 хувиар илүү байна.

Хувийн хэвшлийн эмнэлгүүд 1.2 мянган хүнд үзлэг эмчилгээ оношлогоо хийж 8.8 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс үйлчлүүлэгчид нь 0.2 мян хүнээр, орлого нь 1.0 сая төгрөгөөр бага байна.

Гэмт хэрэг

Оны эхний 2 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 66 болж өнгөрсөн оны мөн үеэс 6.5 хувиар, сүүлийн 4 жилийн дунджаас 15.2 хувиар тус тус өсч, гэмт хэрэгт холбогдогч 63 болж өнгөрсөн оны мөн үеэс 3.3 хувиар өссөн байна.

Бүрт гэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 2 сараар



Гэмт хэрэгт холбогдогчдоос 1.2 хувь буюу 1 эмэгтэй, мөн 1.2 хувь буюу 1 хүүхэд байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хэрэгт холбогдогч эмэгтэйчүүд, хүүхдүүдийн тоо 75.0 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 58.8 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 8.5 хувиар өссөн бөгөөд 82.1 хувь буюу 48.3 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн 16.7 хувийг бүлэглэж үйлдсэн, 21.2 хувь нь согтуугаар үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүлэглэсэн хэрэг


12.3 пунктээр буурч, харин согтуугаар үйлдсэн хэрэг 14.7 пунктээр буюу гаралтын тоо 3.5 дахин өссөн байна.

Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 20.0 хувиар, үүний дотроос иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг 18.7 хувиар тус тус буурч, харин бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 3 дахин өссөн байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 24.3 хувиар, үүний дотроос нийт хулгайн гэмт хэрэг 38.7 хувиар буурсны дотор иргэдийн өмчийн хулгайн хэрэг 40.0 хувиар, малын хулгай 38.1 хувиар, мөн завшин үрэгдүүлэх гэмт хэрэг 20.0 хувиар тус тус буурсан байна.

Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2 дахин, тээврийн хэрэгслэлийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг хэрэг 3 дахин өссөн бөгөөд өнгөрсөн оны мөн үед гарч байгаагүй хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг, залилангийн хэрэг, аж ахуйн нэгжийн эсрэг хэрэг, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, захиргааны журмын эсрэг гэмт хэргүүд 1-10 тохиолдол гарсан байна.

Шүүхээр 20 гэмт хэрэгт 29 хүн ял шийтгүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс шийдүүлсэн гэмт хэрэг 56.5 хувиар, шийтгүүлсэн хүний тоо 62.3 хувиар тус тус буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2010 оны 2-р сард агаарын дундаж температур Улаангом, Баруунтуруун, Давст, Зүүнговь, Тэс - 32.5-ээс -35.8 хэм хүйтэн, хөрсний дундаж температур Зүүнговь, Малчин, Тэс, Түргэн сумдад - 33.9 ээс -35.6 хэм хүйтэн байлаа.

10 м/сек –ээс их салхитай өдөр Өмнөговьд 7, Зүүнговьд 4, Зүүнхангайд 13, Наранбулагт 2 хоног байв.

Баруунтуруунд 7, Өндөрхангайд 4, Малчинд 4, Тэсд 6, Зүүнхангайд 5 хоног тундастай байж нийлбэрээрээ Баруунтуруунд 3.7 мм, Өндөрхангайд 4.1 мм, Хяргаст 4.3 мм, Түргэнд 3.7 мм цас орсон нь аймгийн хэмжээнд хамгийн их тундастай сумдууд болж байна.

Цасны зузаан Баруунтуруун 23 см, Малчин 23 см, Улаангом 25 см, Зүүнговь 22 см, Сагил 22 см, Түргэн 34 см байгаа нь бусад сумдаас харьцангуй илүү байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.ЭРДЭНЭСҮРЭН


12.3 пунктээр буурч, харин согтуугаар үйлдсэн хэрэг 14.7 пунктээр буюу гаралтын тоо 3.5 дахин өссөн байна.

Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 20.0 хувиар, үүний дотроос иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг 18.7 хувиар тус тус буурч, харин бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 3 дахин өссөн байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 24.3 хувиар, үүний дотроос нийт хулгайн гэмт хэрэг 38.7 хувиар буурсны дотор иргэдийн өмчийн хулгайн хэрэг 40.0 хувиар, малын хулгай 38.1 хувиар, мөн завшин үрэгдүүлэх гэмт хэрэг 20.0 хувиар тус тус буурсан байна.

Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2 дахин, тээврийн хэрэгслэлийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг хэрэг 3 дахин өссөн бөгөөд өнгөрсөн оны мөн үед гарч байгаагүй хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг, залилангийн хэрэг, аж ахуйн нэгжийн эсрэг хэрэг, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, захиргааны журмын эсрэг гэмт хэргүүд 1-10 тохиолдол гарсан байна.

Шүүхээр 20 гэмт хэрэгт 29 хүн ял шийтгүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс шийдүүлсэн гэмт хэрэг 56.5 хувиар, шийтгүүлсэн хүний тоо 62.3 хувиар тус тус буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2010 оны 2-р сард агаарын дундаж температур Улаангом, Баруунтуруун, Давст, Зүүнговь, Тэс - 32.5-ээс -35.8 хэм хүйтэн, хөрсний дундаж температур Зүүнговь, Малчин, Тэс, Түргэн сумдад - 33.9 ээс -35.6 хэм хүйтэн байлаа.

10 м/сек –ээс их салхитай өдөр Өмнөговьд 7, Зүүнговьд 4, Зүүнхангайд 13, Наранбулагт 2 хоног байв.

Баруунтуруунд 7, Өндөрхангайд 4, Малчинд 4, Тэсд 6, Зүүнхангайд 5 хоног тундастай байж нийлбэрээрээ Баруунтуруунд 3.7 мм, Өндөрхангайд 4.1 мм, Хяргаст 4.3 мм, Түргэнд 3.7 мм цас орсон нь аймгийн хэмжээнд хамгийн их тундастай сумдууд болж байна.

Цасны зузаан Баруунтуруун 23 см, Малчин 23 см, Улаангом 25 см, Зүүнговь 22 см, Сагил 22 см, Түргэн 34 см байгаа нь бусад сумдаас харьцангуй илүү байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.ЭРДЭНЭСҮРЭН

